

БАТЛАВ:
ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЙГАЛЬ
ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА *Д.МОНХ-ЭРДЭНЭ*

Огноо: 2019 оны 05 дугаар сарын 03

УСА0034 9019197

**“Сум дундын ойн ангийн агротехникийн ажилд
ашиглах тусгай зориулалтын жижиг оврын экскаватор ”
нийлүүлэх үнийн санал авах баримт бичиг**

Тендер шалгаруулалтын нэр/
гэрээний дугаар:

“Сум дундын ойн ангийн агротехникийн ажилд
ашиглах тусгай зориулалтын жижиг оврын
экскаватор худалдан авах”, ГСАОНӨГ/201902036

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Сум дундын ойн ангийн агротехникийн ажилд ашиглах тусгай зориулалтын жижиг оврын экскаватор”-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 00 минутаас** өмнө битүүмжилсэн цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан**2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. “Тооцно”

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг,
Нутгийн удирдлагын ордон, 3-р давхар, 309 тоот өрөө,
Орон нутгийн өмчийн газар, Утас: 70543033, 88723692.**

		Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА
1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа	1.1.	Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх-/д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт	2.1.	Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
3. Тендерийн иж бүрдэл	2.2.	Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
4. Тогтмол үнэ	3.1.	Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
	(а)	Үнийн санал;
	(б)	Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
	(в)	Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
	(г)	Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
	(д)	[Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд	4.1.	Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа	5.1.	Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зэрсэн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх	5.2.	Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл	6.1.	Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
	7.1.	Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
	7.2.	Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
	7.3.	Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
	8.1.	Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОДОХЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>1. Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны санхүүгийн баталгаажуулсан тайлан</p> <p>2. Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны туршлагын мэдээлэл /Өмнө нь ижил төстэй машин механизм нийлүүлж байсан бол давуу тал болох ба гэрээ, барааг хүлээлгэн өгсөн комиссын актын хамт ирүүлнэ./</p> <p>3. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /наториатаар баталгаажуулж ирүүлэх/</p> <p>4. Бүх харилцагч банкны тодорхойлолт /өр зээлийн талаарх мэдээлэл/</p> <p>5. Татварын байгууллагын тодорхойлолт</p> <p>6. Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт</p> <p>7. Шүүх болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт</p> <p>8. Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгийн 80%-иас багагүй байх</p> <p>9. Бараа нийлүүлэлтийн хуваарийг баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>10. Гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг хүлээн зөвшөөрч байгаагаа албан мэдэгдлээр ирүүлнэ.</p> <p>11. Шалгарсан тохиолдолд “Техникийн тодорхойлолт”-д тусгасан шаардлагуудыг зөвшөөрч байгаа талаар албан мэдэгдэл ирүүлнэ.</p> <p>12. Харьяалагдах банк, татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас тодруулга авахад татгалзах зүйлгүй гэсэн албан бичиг ирүүлнэ.</p> <p>13. Нийлүүлэхээр санал болгож байгаа барааны техник үзүүлэлт болон фото зураг бүхий дэлгэрэнгүй танилцуулга ирүүлэх.</p> <p>14. Нийлүүлэхээр санал болгож байгаа бараандаа 1 жилийн чанарын баталгаа өгөх талаар албан мэдэгдэл ирүүлэх.</p> <p>15. Нийлүүлэхээр санал болгосон барааг захиалагчийн заасан цэгт туршилт хийж өгөх албан мэдэгдэл өгөх.</p> <p>16. ТШӨХ-д заасан аль нэг баримт бичгийг дутуу ирүүлсэн буюу ирүүлж буй материал нь тод гаргацтай байх ба засвартай болон харагдах боломжгүй бол ирүүлээгүйд тооцож тендерээс татгалзах үндэслэл болно. /Дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсанаас хойш холбогдох газруудаас гаргуулж эх хувиар ирүүлнэ./</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 МЬ, нэг файлын хэмжээ 15 МЬ байна.</p> <p>Тендер хүлээн авах этгээд: Орон нутгийн өмчийн газар</p> <p>Огноо: 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Цаг: 10цаг 00 минут</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг, Нутгийн удирдлагын ордон</p> <p>Давхар болон өрөөний дугаар: Орон нутгийн өмчийн газар, 3 давхар, 309 тоот</p> <p>Огноо: 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдөр Цаг: 10цаг 30 минут</p>
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Сум дундын ойн ангийн агротехникийн ажилд ашиглах тусгай зориулалтын жижиг оврын экскаватор

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** Сум дундын ойн ангийн агротехникийн ажилд ашиглах тусгай зориулалтын жижиг оврын экскаватор
2. **Стандарт:**
3. **Бараа хүргэх газар:** Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3-р баг, Байгалворчин аялал, жуулчлалын газар.
4. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойл олт	Тоо ширхэг	Хэмжки х нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгч ийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Сум дундын ойн ангийн агротехникийн ажилд ашиглах тусгай зориулалтын жижиг оврын экскаватор	-	1	ширхэг	ГСА, Сүмбэр сум, 3-р баг, НУОрдон	2019.05.20	2019.05.25	


БАГА ОВРЫН ЭКСКАВАТОРЫН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№02

Ногоон байгууламжийн агротехникийн ажилд ашиглах бага оврын
экскаватор нь дор дурдсан техникийн тодорхойлолт, шаардлагад нийцсэн байна.

ЭД АНГИ	ТӨРӨЛ	ҮЗҮҮЛЭЛТ
Үндсэн үзүүлэлт	Шинж байдал	Шинэ /өнгө үзэмж сайн/
	Механизмын зориулалт	Агротехник, газар боловсруулах, модны нүх ухах ажилд ашиглах зориулалттай
	Нийт жин	Бага оврын буюу бүх жин нь 4000 кг-с ихгүй
	Нийт урт	Нийт урт- 3700 мм-с багагүй / шанага тэнийлгээгүй байх үед/
	Нийт өргөн	Механизмын суурын өргөн 990 мм-с багагүй
	Шанганы эзэлхүүн	0,2 м/куб-с багагүй
	Нэмэлт шаардлага	Механизмын шанагыг сольж өрөм залган нүх ухаад ашиглах боломжтой. /өрмийг хамт санал болговол давуу тал болно/
	Ухах гүн	2000 мм-с багагүй
	Үйлдвэрлэсэн он	2017 оны 01 сараас хойш
	Монгол улсад орж ирсэн он	2018 он буюу түүнээс хойш
Явах анги	Насос	Гидр
	Дугуйн хэмжээ	Дугуйт болон гинжит / дугуйтай бол давуу талтай/
Хөдөлгүүр	Элэгдэл	Элэгдэл бага, цаашид хэвийн ашиглах боломжтой
	Шатахууны төрөл	Дизель
	Моторын чадал	10,2 kw/ 17.5/ kw -с багагүй
	Бусад шаардлага	Ажиллагаа хэвийн гэмтэл доголдолгүй, жиригэг, сальник, шланкаар тос гоожоогүй байх, тосолгоо үйлчилгээ хийлгэх боломжтой байх.
	Нэмэлт	Нийлүүлэгчээс олгох баталгаат хугацаа 1 жил Монгол улсад сэлбэгийг худалдан авах, засвар үйлчилгээ хийлгэх боломжтой байх
	Ашиглалтын зааварчилгаа	Монгол хэл дээр бэлтгэж өгөх

Жич: Солонгос болон Хятад улсад үйлдвэрлсэн экскаватор байж болно.

Боловсруулсан:  Д.Мөнх-Эрдэнэ

VCA 0034 9019197

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [too] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал Үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

**2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО
ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа 2 жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш ГТНөхцөлд тусгагдсаны дагуу хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|--|--|
| <p>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</p> | <p>1.1. Тендер шалгаруулалтад шалгарсан гүйцэтгэгч нь жижиг оврын экскаваторыг хүлээлгэн өгөхдөө асааж, ажилуулж ашиглагч байгууллагын жолоочид ажиллах горимыг тайлбарлан хүлээлгэж өгнө.</p> |
| <p>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</p> | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none">1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| | <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| <p>3. Баталгаат засвар (ГЕН-5)</p> | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
Баталгаат засварын хугацаа 2 жил байна.</p> |
| <p>4. Төлбөр (ГЕН – 7)</p> | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p>Урьдчилгаа төлбөр: Урьдчилгаа төлбөр 30%.</p> <p>Барааг хүлээн авахад төлөх төлбөр: Ирсэн барааны гэрээний үнийн 70 хувьтай тэнцэх дүнг бараа ирснээс хойш 10 хоногийн дотор нэхэмжлэх болон захиалагчийн бараа хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнэ.</p> |
| <p>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)</p> | <p>9.1. Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн хоног тутамд гэрээний үнийн дүнгийн 0,5</p> <p>Алдангийн нийт дүн: гэрээний үниийн дүнгийн 10 хувь</p> |
| <p>6. Гэрээний сунгалт:</p> | <p>Захиалагч болон нийлүүлэгч талаас шууд хамааралгүй гадны болон байгаль цаг уурын давагдашгүй хүчин зүйлийн улмаас талууд харилцан хүлээн зөвшөөрсөний үндсэн дээр гэрээний хугацааг 1 удаа сунгаж болно.</p> |

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ¹

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

- Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны _____ дугаар сарын _____-наас _____ оны _____ дугаар сарын _____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг²;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

¹ Гэрээ байгуулах үед үүний хасна.

² Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]